

Төсөл
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
сайдын 2020 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн дугаар тушаалын хавсралт

МАЛ ҮРЖҮҮЛЭГ, ТЕХНОЛОГИЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГЖИД ИТГЭМЖЛЭЛ ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, СУНГАХ, БҮРТГЭХ, ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Малын генетик нөөцийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-ээс 11.5 дахь заалтын дагуу мал аж ахуйн мэргэжилтэнд итгэмжлэл олгоход энэхүү журмыг баримтална.

1.2 Мал аж ахуйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэлийг Малын генетик нөөцийн тухай хуулийн 16.8-д заасны дагуу мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж, мал зүйчид олгоно.

1.3 Мал аж ахуйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэл олгосон нэгж, мэргэжилтэн нь баталгаажсан үүлдэр ба омгийн цөм болон үржлийн сүргийн үржил-селекцийн ажлыг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан стратеги төлөвлөгөөний дагуу гардан хариуцах, малчид, мал бүхий иргэдтэй хамтран ажиллаж Малын генетик нөөцийн тухай хуулийн 11.6 заалт, 13 дугаар зүйл ба 15.2 дахь заалтын холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

1.4 Зөвхөн хуулийн этгээдийн нэрээр итгэмжлэл олгох ба энэ тохиолдолд тухайн байгууллагын удирдах албан тушаалтан болон мэргэжилтний нэрийг заах, нэр дээр нь бичилт хийхийг хориглоно.

1.5 Бүх шатны төрийн албан хаагчид итгэмжлэл олгохгүй бөгөөд уг албыг хашаагүй тохиолдолд энэ журамд заасны дагуу иргэний хүсэлтийн журмаар шийдвэрлэж болно.

1.6 Малын генетик нөөцийн тухай хуулийн 11.1-д заасан мал үржлийн үйл ажиллагааг 10 ба түүнээс дээш жил тогтвортой эрхэлж, мэргэжлийн ажил үйлчилгээгээр бий болгох үр дүнд хүрсэн/хүрч буй мал зүйч бус мэргэжлийн иргэнд итгэмжлэлийг Малын генетик нөөцийн тухай хуулийн 11.3-д заасны дагуу олгож болно.

1.7 Гадаадын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй иргэнд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэл олгохгүй.

1.8 Дотоодын байгууллага, Монгол улсын иргэнтэй хамтран итгэмжлэл авах хүсэлтийг хүлээн авах, итгэмжлэл олгохыг хориглоно.

1.9 Мал үржлийн ажил үйлчилгээ үзүүлэх итгэмжлэл тухайн этгээдийн харьяа юм уу оршин суугаа сум, дүүрэг, баг хороонд хүчинтэй байна. Хэрэв өөр сум, дүүрэгт үйлчилгээ эрхлэх бол тухайн сум, дүүргээс итгэмжлэл авна. Үйлчилгээний нэгж бүр нэг дүүрэг, хоёр хүртэл суманд итгэмжлэлтэй ажиллахыг зөвшөөрнө.

1.9.1 Мэргэжлийн итгэмжлэл олгох асуудлыг хянан шийдвэрлэхдээ хуулийн Малын генетик нөөцийн тухай хуулийн 17.5.3-д заасны дагуу Үндэсний зөвлөлдөх хорооноос гаргасан зөвлөмжийг харгалзана. *(зөвлөлөөс тухайн үүлдрийн малыг цаашид үржүүлэх, гадаадаас мал нэмж авах шаардлагагүй тухай зөвлөмж гаргавал бол итгэмжлэл олгохгүйгээс гадна олгогдсон итгэмжлэлийг цуцалж болно)*

Хоёр Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэлийн шатлал, итгэмжлэл олгох

2.1 Малын генетик нөөцийн тухай хуулийн 11.4-д заасны дагуу мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний итгэмжлэл дараах шатлалтай байна.

2.1.1.1 Цөм сүргийн үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний

2.1.1.2 Үржлийн сүргийн үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний

2.2 Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж, мал аж ахуйн мэргэжилтэн нь итгэмжлэл авах хүсэлтээ Малын генетик нөөцийн тухай хуулийн 16.8-д заасан байгууллагад 3 сарын өмнө бичгээр холбогдох бусад баримт бичгийн хамт гаргана.

2.3 Мал аж ахуйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж нь дараах шаардлага, нөхцлийг хангасан байна. Үүнд:

2.3.1 Малын генетик нөөцийн тухай хуулийн 11.2 дахь заалтыг итгэмжлэл олгох гол үндэслэл болгон харгалзаж үзэх.

2.3.2 Малын генетик нөөцийн тухай хуулийн 19 дүгээр заалтад тусгагдсан холбогдох арга хэмжээг уг хуулиар тогтоосон хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой байх

2.3.3 Мөн хуулийн 16.10-д заасны дагуу бүртгүүлсэн байх

2.3.4 Тодорхой үүлдэр, омгийн үржлийн ажлыг сүүлийн 3 ба түүнээс дээш жил дагнан болон бусад байгууллага, мэргэжилтэнтэй тасралтгүй хамтран гүйцэтгэж, оролцож ирсэн, цаашид үргэлжлүүлэх ажиллах хүсэл сонирхолтой.

2.3.5 Тухайн сум, дүүрэгт үржүүлж буй баталгаажсан үүлдэр, омгийн үржлийн ажлыг энэхүү журмын 1.3-д заасны дагуу 5 жилээс дээш хугацаагаар хариуцан гүйцэтгэхээр тухайн шатны Засаг дарга, Хөдөө аж ахуйн тасагтай хүчин төгөлдөр гэрээ байгуулсан

2.3.6 Малын генетик нөөцийн тухай хуулийн 16.3-д заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр Монгол улсад заагдсан бүс нутагт үржүүлж нутагшуулахаар өөрийн хөрөнгөөр болон бусад эх үүсвэрээс гадаадаас цэвэр үүлдрийн үхэр, хонь, шувуу, гахай импортлосон хуулийн этгээд нь мөн хуулийн 11.2-д заасан шаардлагыг бүрэн хангасан, энэ тухай 16.2-д заасан тухайн орон нутгийн байгууллагаас албан ёсны тодорхойлолт гаргуулсан байх

2.3.7 Малын генетик нөөцийн тухай хуулийн 16.10.3-д заасан бизнес төлөвлөгөөг үйл ажиллагааны задаргаатайгаар 5 жилээр боловсруулсан, доор дурдсан тооцоо, үзүүлэлтийг тусгасан байх

2.3.7.1 Цөм сүргийн үржүүлэх чиглэлээр итгэмжлэр авах этгээд уг сүргийн сүүлийн 5 жилийн өсөлт, анги чанарын болон ашиг шимийн дундаж (дээд болон доод) үзүүлэлтэд гарсан тооны ба чанарын өөрчлөлт, итгэмжлэл олгогдсон 5 жилд хүрэх түвшинг харуулсан тооцоо хийсэн байх

2.3.7.2 Үржлийн буюу цөм сүргийн бус сүрэгт үржил-селекцийн ажил явуулах итгэмжлэл авсан этгээд тухайн үүлдрийн цөм сүрэгт хээлтүүлэгч нийлүүлэхтэй холбогдсон тооцоо, үнэлгээ хийсэн байх

2.4 Мал аж ахуйн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн байгууллагад үндэсний хэмжээнд, харин тэдгээрийн салбар, станцад тухайн бүс нутгийн түвшинд үйлчилгээ явуулах хязарлалттайгаар итгэмжлэл олгож болно.

2.5 Цөм сүргийн улсын үйлдвэрийн газарт хуулийн этгээдийнхтэй адилтгах итгэмжлэл олгоно.

2.6 Нэг үүлдэр, омгийн болон ашиг шимийн ижил чиглэл бүхий мал, амьтны маллагаа, үржүүлгийн чиглэлээр олгох итгэмжлэлийн тоог хязгаарлахгүй. Гэхдээ нэг сум, дүүрэгт нэг үүлдэр, омгийн мал дээр зөвхөн нэг этгээдэд нэг итгэмжлэл олгоно.

Гурав Мал аж ахуйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэл олгоход харгалзах болон татгалзах нөхцөл, хориглох үндэслэл

3.1 Малын генетик нөөцийн тухай хуулийн холбогдох заалт, энэхүү журамтай нийцэж байвал энэхүү журам мөрдөгдөхөөс өмнө олгогдсон итгэмжлэлийг хүчинтэйд тооцож болно.

3.2 3.1-д заасан шаардлагыг хангаагүй бол уг итгэмжлэлийг хүчингүй болгож шинээр олгоно.

3.3 Энэ журамд өөрөөр заагаагүй бол итгэмжлэлийг эхний удаа 5 хүртэл жилээр олгох ба мөн хугацаагаар нэг удаа сунгана. Энэхүү сунгасан хугацаа дууссан тохиолдолд цаашид сунгуулахаар хүсэл гаргаж болох бөгөөд түүнийг Малын генетик нөөцийн тухай хуулийн 16.3-д заасан эрх бүхий байгууллага хянан шийдвэрлэнэ.

3.4 Үржлийн бус, зөвхөн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зориулалтаар, тухайлбал маханд борлуулах мал, тэжээвэр амьтан маллах, бордох хуулийн этгээд, иргэнд мэргэжлийн итгэмжлэл олгохгүй.

3.5 Өсвөр хээлтүүлэгч, хээлтэгч бусад орноос оруулж түр борлуулдаг этгээдийн тусгай зөвшөөрөлтэй давхардуулж итгэмжлэл олгохгүй

3.6 Судалгаа, туршилт, сургалтын зориулалтаар мал, тэжээвэр амьтныг цөөн тоогоор түр маллаж ашиглахад мэргэжлийн итгэмжлэл олгохгүй.

3.7 Итгэмжлэл шинээр олгосон, хугацааг сунгасан, итгэмжлэлийн дагуу гүйцэтгэх үйл ажиллагаанд нэмэлт өөрчлөлт оруулсан бол сумын хөдөө аж ахуйн тасгаар дамжуулан сум, дүүргийн иргэдэд 7 хоногийн дотор зарлан мэдээлнэ.

3.8 Итгэмжлэлийг бусдад шилжүүлэх, барьцаалах, ашиглуулахыг хориглоно.

Дөрөв. Мал аж ахуйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэлийг цуцлах, хүчингүй болгох

4.1.Итгэмжлэлд зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэхэд түүнийг ашигласан болон ашиглаж байгааг хэрэглэгч/үйлчлүүлэгчдээс нотолсон, эсвэл албан ёсны хяналтаар илэрсэн бол цуцална. Ийм зөрчил гаргасан этгээдэд итгэмжлэл дахин олгохгүй.

4.2.Итгэмжлэл олгох эрх бүхий байгууллага татан буугдсан, үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн бол итгэмжлэлийг хэвээр ашиглуулах, хүчингүй болгох, шинэчлэх асуудлыг тухай бүр шийдвэрлэнэ.

4.3.Итгэмжлэл бүхий хуулийн этгээд татан буугдвал итгэмжлэлээ цуцлуулах хүсэлтээ харьяа сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасагт албан ёсоор заавал мэдэгдэж зуучлуулан холбогдох байгууллагад хүргүүлнэ.

4.4.Итгэмжлэлээ цуцлуулахаар ирүүлсэн хүсэлтийг хүлээн авсан өдрөөс ажлын 10 хоногт багтаан шалган шийдвэрлэж зарлана.

Тав. Хариуцлага

5.1 Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oOo-----



МОНГОЛ УЛС

..... АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ ГАЗАР
МАЛЫН ҮРЖЛИЙН ХЭЛТЭС

ИТГЭМЖЛЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Овог

Нэр

Аж ахуй нэгжийн нэр

Үйл ажиллагааны чиглэл

.....

.....

.....Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ гүйцэтгэх
ИТГЭМЖЛЭЛИЙГ оны сарын... өдрөөс оны ... сарын ... өдөр хүртэл
жилийн хугацаагаар олгов.

.....АЙМГИЙН ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙ ГАЗРЫН ДАРГА
.....

тамга, гарын үсэг

.....АЙМГИЙН ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙ ГАЗРЫН МАЛЫН
ҮРЖЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ЕРӨНХИЙ МАЛ ЗҮЙЧ

тамга, гарын үсэг